

Калифорнийн сонгогчдод зориулсан хэлний тусламж

2020 оны арваннэгдүгээр сарын сонгуулийн талаар таны мэдэж
байх ёстой бүхнийг Монгол хэлээр

Товч зөвлөгөө!

Өөрийн илүүд үзсэн хэлээ шинэчлэхийн тулд <https://voterstatus.sos.ca.gov> руу орох юмуу сонгуулийн албатайгаа утсаар харилцана уу. Хэрвээ танай хэсэгт орчуулсан материалууд байгаа бол тэд тань руу үнэ төлбөргүйгээр шуудангаар илгээх болно.

Хэрвээ та доорх каунтийн аль нэгэнд амьдардаг бол:

Аламеда (510) 272-6973	Лос Анжелес (800) 815-2666
---------------------------	-------------------------------

Хэрвээ та гэрээсээ санал өгч байгаа бол: Таны хаана амьдарч буй эсэхээс хамаарч Монгол хэл дээрх “факс” саналын хуудсыг шуудангаар илгээж болно. Факс санал хуудас нь таныг Англи саналын хуудсыг ойлгож бөглөхөд тусалдаг орчуулагдсан загвар санал хуудас (санал өгөхгүй) юм. Факс саналын хуудсыг асуух юмуу илүүд үзсэн хэлээ шинэчлэхийн тулд каунтийн сонгуулийн албатай холбогдох юмуу <https://voterstatus.sos.ca.gov> сайтад зочилно уу.

Хэрвээ та өөрийн биеэр очиж санал өгч байгаа бол: Хэлний тусламж нь таныг хаанаас санал өгөхөөр бүртгүүлснээс хамаарна. Хэрвээ Монгол хэлний тусламж байгаа бол орчуулгын тэмдэг болон “факс” саналын хуудсыг тодорхой хэвлэсэн байна. Англи хэлээрх саналын хуудсан дээр санал өгөхөд танд туслахы тулд санал хураах цэг рүү авч очих хуулбарууд бий.

Өөрийн биеэр очиж санал өгөхдөө та аман тусламжийг авч болно:

Санал хураах газар юмуу санал хураах төвд Монгол хэлээр ярьдаг сонгуулийн санал хураалтын ажилтан байгаа бол тэднийг ямар хэлээр ярьдгийг илэрхийлсэн **тэмдэг, тууз, наалт зүүсэн байна.** Монгол хэлээр ярьдаг эсэхийг илэрхийлсэн тэмдэг байх ёстой.

Таны ажил олгогч юмуу холбоог төлөөлөхгүй **хоёр хүртэл хүнийг авчирахыг** танд зөвшөөрнө. Гэр бүлийн гишүүн юмуу найз нөхдийг авчирч болно!

Хэрвээ та дээр жагсаагаагүй каунтид амьдардаг бол Монгол хэлээрх саналын хуудас болон туслалцаа байхгүй.